



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 32

Есөнбулаг сум

**Цээл сумын Сайр нэртэй талбайд ашигт
малтмалын хайгуулын лиценз хүссэн
өргөдөлд санал өгөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цээл сумын нутаг Сайр нэртэй талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс дэмжихгүй байгааг үүгээр уламжилсугай.
2. Уг шийдвэрийг холбогдох материалын хамт Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Гансалэм/-д даалгасугай.


 ДАРГА Т. ГАНЗОРИГ